



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Ж.БАЯРМАА ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.06.04 № ХХТ/1611

танай _____-ны № _____-т

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Таны санаачлан боловсруулсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хавсралт ² хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Н.УЧРАЛ

100255009782

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 25 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“25.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нараас санаачлан боловсруулсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нараас санаачлан боловсруулсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд дараах үндэслэлээр дэмжих боломжгүй саналыг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

1.Татварын ерөнхий хуулийн 5.1 дэх хэсэгт татвар тогтоох, ногдуулах, тайлагнах, төлөх, хөнгөлөх, чөлөөлөх үйл ажиллагаанд “шударга байх”, “үр ашигтай байх” татварын тогтолцооны суурь зарчмыг баримтлахаар заасан.

“Шударга байх” зарчим нь татвар төлөгчийн хөрөнгө, орлого, хэрэглээний хэмжээнээс хамаарч төлбөл зохих татварыг ялгаатай тогтоох агуулгыг илэрхийлэх бөгөөд дэлхий нийтэд энэхүү зарчмыг шаталсан татварын тогтолцоогоор хэрэгжүүлдэг нийтлэг жишигтэй. Өөрөөр хэлбэл, нийгмийн баялгаас хэн их хүртэж байгаа нь эргээд нийгэмдээ төдий хэмжээгээр төлөх агуулгын хүрээнд татварын ачааллыг төлөх чадварт нь хувь тэнцүүлэн ногдуулдаг.

Энэ утгаараа хувь хүний орлогын албан татвар нь орлогын тэгш бус байдлыг бууруулах, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор орлогын дахин хуваарилалт хийх чухал механизмын нэг болдог. Монгол Улсын хувьд хувь хүний орлогын албан татварын нийт орлогын 71 хувийг хамгийн өндөр орлоготой хэсэг буюу 13 хувь нь татварыг бүрдүүлдэг. Энэ нь татвар төлөгчдийн орлогын тархалт тэгш бус байдаг тул орлогын тэгш бус байдлыг бууруулахад татварын суурь тогтолцооны тогтвортой байдлыг хангах зарчим баримталж, татварын бодлогоор зохицуулалт хийх шаардлагатайг харуулж байна.

Иймд хуулийн төсөлд заасны дагуу бүх төрлийн орлогын албан татварын хувь хэмжээг орлогын хэмжээнээс үл хамааран 1 хувь болгож бууруулах нь орлого, хөрөнгө ихтэй чинээлэг иргэдэд давуу байдал олгосон, шударга бус зохицуулалт болох бөгөөд энэ нь татварын шударга байх зарчимтай зөрчилдөж байна.

Түүнчлэн, татварыг бодлогоор бус, татварын хувь хэмжээг хэт бага буюу 1 хувь болгох байдлаар бууруулах тохиолдолд төсвийн орлого нэмэгдэхгүй төдийгүй, татварын тайлан, хяналт, бүртгэл зэрэг хэрэгжилтийн зардал нь татварын орлогоос давж, татварын “үр ашигтай байх” зарчим алдагдах эрсдэлтэй байна.

2.Монгол Улсын хувьд “хувь хүний орлогын албан татвар” нь Төсвийн тухай хуулийн 23.8.1, 23.8.17 дахь заалтад заасны дагуу сум, дүүргийн төсвийн татварын орлогыг бүрдүүлдэг бөгөөд орон нутгийн төсвийн орлогын 52 орчим хувийг бүрдүүлэн, тухайн шатны төсвийн гол эх үүсвэр болж, эдийн засгийн аль ч мөчлөгийн үед тогтвортой орлогыг бүрдүүлдэг онцлогтой татвар юм.

Хуулийн төсөлд тусгасны дагуу татварын хувь хэмжээг огцом бууруулах нь орон нутгийн төсвийн орлогыг нийт 2.8 орчим их наяд төгрөгөөр бууруулахын зэрэгцээ сум, дүүргийн хэмжээнд төрийн үйл ажиллагааг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрс бууруулах нөхцөлд хүргэж болзошгүй байна. Ингэснээр орон нутгийн засаг захиргааны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэх, аймаг, нийслэлийн хэмжээнд төсвийн байгууллагуудын төрийн үйлчилгээ доголдох сөрөг нөлөөтэй байна.

Түүнчлэн хуулийн төслийн хүрээнд орон нутгийн төсвийн алдагдал нэмэгдэх үр дагавартай байгаа тул улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг огцом нэмэгдүүлэх шаардлага үүсэх, улмаар орон нутгийн эдийн засгийн бие даасан байдалд сөрөг нөлөө үзүүлэх, улсын төсвөөс хараат байдлыг нэмэгдүүлэх зэрэг эрсдэлтэй байна.


Мөн уул уурхайгаас өндөр хамаарал бүхий төсвийн бүрдэлтэй манай улсын хувьд төсвийн тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэх, урт хугацаандаа гадаад орчны савлагаанд өртөх, эдийн засгийн хүндрэл үүсэх, улмаар өрийн дарамт нэмэгдэх, зээлжих зэрэглэл буурах зэрэг ноцтой эрсдэлүүд үүсэхээр байна.

3.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд уг төсөлд төсвийн төсөөллийн үзүүлэлтүүдийг боловсруулахдаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1 дэх хэсэгт заасан тусгай шаардлагууд хангасан байх шаардлагатай.

Харин дээрх хүрээний мэдэгдэлд тэнцвэржүүлсэн орлого, нэгдсэн төсвийн суурь тэнцэл, нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээг тооцоход тус хуулийн төслийн татварын хувь хэмжээний огцом өөрчлөлтийн нөлөө тусгагдаагүй байгаа нь төсвийн богино, дунд хугацааны бодлого, стратегийн зорилт бүхий төсвийн удирдлагыг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж, төсвийн тусгай шаардлага хангагдахгүй нөхцөлд хүргэснээр төсвийн тогтвортой байдлыг алдагдуулах эрсдэлтэй байна.

Түүнчлэн, Татварын ерөнхий хуулийн 4.2-т “Татварыг хөнгөлөх, чөлөөлөх, татварын хувь, хэмжээ болон татварын суурийг бууруулахтай холбогдсон хуулийн төслийг тухайн жилийн төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт боловсруулна.” гэж заасантай зөрчилдөхөөр байна.

4.Төсвийн тухай хуулийн 6.2.4-т “Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засгийн газар, Засаг даргын аливаа шийдвэр нь төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх дүгнэлтэд үндэслэсэн байх” гэж заасан тул хуулийн төслийг хэрэгжүүлснээр төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх дүгнэлтийг хийх шаардлагатай байна.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР